

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР  
2011 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ**


(2011 оны 1 дүгээр улирлын байдлаар)

**Нэг. Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд**

**1.1 Дунд хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг нэг оронтой тооноос хэтрүүлэхгүй байх бодлого баримтална.**

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр ХҮИ-ээр тооцсон инфляци 2011 оны 3 дугаар сарын эцэст улсын хэмжээнд жилийн 8.0 хувь, Улаанбаатар хотод 7.4 хувь болж өмнөх саруудаас буурч гарав (Зураг 1.1а). 3 дугаар сард махны үнэ буурч, инфляцийн бүтцэд хүнс, түүн дотроо махны үнийн өсөлт голлож байсан нь өөрчлөгдөн бусад өргөн хэрэглээний үнийн өсөлт ил боллоо (Зураг 1.1б). Үнийн өсөлтийг барааны бүлгүүдээр авч үзвэл 2011 оны эхний улирлын эцэст хүнсний барааны үнэ жилийн 6.3 хувиар өссөн нь жилийн инфляцийн 36.2 хувийг; хувцас, бөс барааны үнэ 11.05 хувиар өссөн нь жилийн инфляцийн 18.9 хувийг; орон сууц, ус цахилгааны үнэ 10.09 хувиар өссөн нь жилийн инфляцийн 18.7 хувийг; боловсролын үнэ 20.3 хувиар өссөн нь жилийн инфляцийн 11.7 хувийг тус тус бий болгожээ (Зураг 1.1в).

Зураг 1.1 а. Жилийн инфляци




Эх үүсвэр: УСХ

Зураг 1.1б. Жилийн инфляцийн задаргаа

Зураг 1.1в. Инфляцийн задаргаа<sup>1</sup>

<sup>1</sup>Оны эхнээс тооцсон инфляци.



Эхсурвалж: УСХ

Хэрэглээний үнийн хэлбэлзэлд махны үнийн нөлөө их хэвээр байна. Энэ удаад махны нөөц их бэлтгэсэн, махны олон улсын худалдааг хязгаарласан зэрэг нь хүчтэй нөлөө үзүүлж байна. Цаашид махны хангалтыг томоохон нөөцөөр дамжуулах нь хэрэглээний үнийн тогтвортой байдалд чухал нөлөөтэй байгаа нь энд харагдаж байна. ХХС-аас олгож буй бэлэн мөнгө, хөрөнгийн дотогшлох урсгалыг төгрөг болгосны үр дагавар зэрэг инфляцийн дарамт үзүүлэх хүчин зүйлсийг ялгаж тооцоход хэрэглээний үнийн ийм өндөр хэлбэлзэл садаа болж байгааг энд дурьдаж байна.

Монголбанкнаас үнийн өсөлтийг сааруулах, цаашид мөнгөний нийлүүлэлтээр түүнийг тэтгэхгүй байх, ХХС-аас бэлэн мөнгө тараах, уул уурхайн томоохон төслүүдийн хөрөнгө оруулалт зэрэг эрэлтийн гаралтай инфляцийн дарамтын эсрэг мөнгөний бодлогыг чангатгаж, банкуудын заавал байлгах нөөцийн хувийг 4 нэгж хувиар өсгөв. Бодлогын энэхүү арга хэмжээ нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, түүний хямралд өртөмтгий эмзэг байдлыг багасгах, гадны гэнэтийн сөрөг нөлөөлөлд цочрохгүй байх чадварыг нэмэгдүүлэх давхар зорилготой болно.

**Хүснэгт 1.1. Инфляци, мөнгөний нийлүүлэлтийн үндсэн үзүүлэлт (хугацааны эцэст, өөрөөр заагаагүй бол өөрчлөлтийн хувь)**

Үзүүлэлт	III.2009	III.2010	III.2011	<u>XII.2011</u> <u>XII.2010</u>
<b>Инфляци, жилийн өөрчлөлт</b>				
УБ хотын	17.2	1.9	8.0	
Улсын	16.3	8.5	7.4	
<b>Мөнгөний нийлүүлэлт, тэрбум төгрөг</b>	<b>2352.5</b>	<b>2974.4</b>	<b>4955.1</b>	<b>1.665</b>
M1 мөнгө	511.3	693.0	1181.5	1.705
Бараг мөнгө	1841.1	2281.4	3773.5	1.654
Нөөц мөнгө	587.7	678.0	1016.7	1.499
<b>Зээлийн хүү, жилийн</b>				
Төгрөгийн зээлийн нэрлэсэн хүү	20.4%	20.0%	15.8%	
Валютын зээлийн нэрлэсэн хүү	19.4%	14.9%	13.0%	

Эх үүсвэр: УСХ, Монголбанкны сарын статистикийн мэдээлэл

Инфляци, макро эдийн засгийн зарим үзүүлэлтүүдийн таамаглалыг гурван өөр загвараар тооцож, тэдгээрийн үр дүнг дундажлан нэгтгэж бодлогын шийдвэр гаргахад ашиглаж байна. Эдгээр загваруудын таамаглах чадварыг дээшлүүлэх нь таамаглалын алдааг бууруулж, ирээдүйгээ харсан мөнгөний бодлогын төлөвлөлт, хэрэгжилт, үр нөлөөнд чухал ач холбогдолтой тул загваруудын үнэлгээнд сүүлийн үеийн тоон шинжилгээний аргыг нэвтрүүлж ажиллалаа. Тухайлбал, дээрх 3 загварын инфляцийн

дундаж таамаглалын тодорхой бус байдлыг илтгэсэн график хэлбэрээр мэдээлж, SVAR загварын үнэлгээг Бейсийн аргаар үнэлсэн бөгөөд одоогоор таамаглал, симуляци шинжилгээг нь сайжруулахаар ажиллаж байна. Мөн сүүлийн үед төв банкууд шийдвэр гаргахдаа ашиглаж байгаа динамик, стохастик ерөнхий тэнцвэрийн загварыг төлөвлөгөөний дагуу судалж, эхний хувилбарыг танилцуулахаар бэлтгэж байна.

**1.2 Эдийн засгийн хямралд өртөмтгий эмзэг байдалд хүргэхгүй байх, хямралыг сөрөх чадавхийг бий болгох зорилгоор макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын эрүүл, зохистой байдлын шинжилгээг хийж, төрийн мөнгөний бодлогод тусган хэрэгжүүлнэ.**

Эдийн засгийг хямралд өртөмтгий эмзэг байдалд хүргэхгүй байх, хямралыг сөрөх чадавхийг бий болгох зорилтын хүрээнд макро зохистой бодлогыг судлан өөрийн орны онцлогт тохирсон бодлогын тогтолцоог бий болгох, төлбөрийн тэнцлийн дунд хугацааны төсөөлөл, Монгол улсын гадаад зээлийн тайлан, олон улсын хөрөнгө оруулалтын позицитай тайланг гаргаж дүгнэлт хийж, арга хэмжээ авч байх ажлыг хийж эхлээд байна. Үүнээс макро зохистой бодлогыг боловсруулах ажлын хүрээнд урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах санхүүгийн болон макро эдийн засгийн орчинг бүрдүүлэх зорилгоор макро зохистой бодлогын талаарх онол, практикийг судлан, өөрийн оронд тохирсон макро зохистой харьцааны үзүүлэлтүүдийг боловсруулах, өнөөгийн бодлогод холбогдох дүгнэлт өгөх ажлууд хийж байна.


Макро зохистой бодлогод хамаарах нэг чухал асуудал нь санхүүгийн хөрөнгийн хил давсан урсгалын тухай зөв мэдээлэлтэй байх, бизнес эрхлэгчдийн ажлыг хохироохгүй хяналтын тогтолцоо бүрдүүлэх асуудал юм. Энэ ажлыг хэрэгжүүлэхэд БНСУ-ын туршлагыг судлах үүднээс хоёр улсын Засгийн газар хоорондын мэдлэг хуваалцах туслалцааны хүрээнд судалгаа хийхээр зохион байгуулж эхлээд байна.

Макро зохистой бодлогын эцсийн зорилго нь санхүүгийн тогтвортой байдал юм. Манай санхүүгийн системд гадаадын хөрөнгө өр болон өмчийн хэлбэрээр байрших нь нэмэгдэж байгаа энэ үед банкуудын гадаад валютын заавал байлгах нөөцийн хэмжээг нэмэгдүүлсэн нь санхүүгийн салбарын хямралыг даван туулах чадварыг бэхжүүлэх зорилттой нийцэж байна. Макро эдийн засгийн эмзэг байдлыг олон улсын зээлжих зэрэглэл тогтоох байгууллагууд үнэлэхдээ Монгол улс мөчлөг сөрсөн макро бодлого хэрэгжүүлдэггүй, инфляцийн эсрэг авах арга хэмжээ нь сул гэж дүгнэж байна. Мөн төсвийн зарлагын хэмжээ ихээхэн өссөн, төсвийн алдагдал ихтэй зэргийг оруулж дүгнэжээ. Цаашид макро эдийн засгийн бодлого зохистой байхын үндэс нь төрийн сангийн мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлж, урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг гол чиглэл болгох нь зүйтэй байна.

**1.3 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж уян хатан тогтох зарчмыг баримтална. Монголбанк дотоодын зах зээлд гадаад валютын ханшийн огцом өөрчлөлтийг зөөлрүүлэх чиглэлээр оролцож, гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлнэ.**

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2011 оны 1 дүгээр улиралд 4.9%-иар чангарч 1195.27 төгрөгт хүрлээ. Энэ хугацаанд ханш нэг өдөрт дундачаар 0.08% хэлбэлзэж, чангарч, суларсан дундаж хэмжээ харгалзан 0.24%, 0.19% байв.

**Зураг 1: Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн хөдөлгөөн**



Эх сурвалж: Монголбанк

**Зураг 2: Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн нэг өдрийн өөрчлөлт**




Эх сурвалж: Монголбанк

2011 оны 1 дүгээр улирлын байдлаар гадаад валютын дотогшлох цэвэр урсгал 177 сая ам.доллартай тэнцэх хэмжээнд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 12 дахин, үүнээс ам.долларын дотогшлох цэвэр урсгал 251 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 293 сая ам.доллараар өссөн байна. Үүний улмаас төгрөгийн ханш чангарч байна.

Хэдийгээр гадаад валютын дотогшлох урсгал нэмэгдэж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш чангарах хандлагатай боловч i) 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс өнгөрсөн оны мөн үеэс 7.9%-иар буурсан, ii) гадаад худалдааны алдагдал 5.4 дахин өссөнөөс гадна валютын төлбөртэй барааны гадаад худалдааны алдагдал 135.7 сая ам.доллараар буюу 19.2 дахин өссөн зэрэг макро эдийн засгийн суурь нөхцөлүүд нь төгрөгийн ханшийн чангаралтыг сааруулах нөлөөтэй байна.

**Зураг 3: Гадаад худалдааны нөхцөлийн индекс /2000.01=100/**



Эх сурвалж: Монголбанк, ГЕГ

**Зураг 4: Гадаад худалдааны нөхцөлийн өөрчлөлт /хувиар/**



Эх сурвалж: Монголбанк, ГЕГ

**Монголбанк дотоодын зах зээлд гадаад валютын ханшийн огцом өөрчлөлтийг зөөлрүүлэх чиглэлээр оролцоно.**

Дээрх шаардлагын улмаас Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх чиглэлээр захын үйл ажиллагаанд шаардлагатай үед оролцон, зохицуулалт хийж байсан. Тухайлбал, 2010 оны 12 дугаар сараас 2011 оны 1 дүгээр сарыг дуустал хугацаанд гадаад валютын дотогшлох цэвэр урсгалын хэмжээ 521 сая ам.долларт хүрч өссөн нь захыг тогтворгүйжүүлэх, захад оролцогчдын хүлээлтэд сөргөөр нөлөөлөх, төгрөгийн ханш огцом чангарах дарамтыг бий болгох эрсдэлийг бий болгосон. Дээрх нөхцөлд Монголбанк гадаад валютын зах дахь илүүдэл

ам.долларыг худалдан авах замаар ханшийн огцом өөрчлөлтийг зөөлрүүлж, гадаад валютын захын тогтвортой байдлыг хангасан болно.

Банк хоорондын зах дахь гадаад валютын арилжаанд Монголбанк санхүүгийн үүсмэл хэрэгслийг нэвтрүүлсэн нь зах зээлд оролцогчид ханшийн эрсдэлээс хамгаалагдах, төгрөгийн спот захын дарамтыг бууруулах үндсэн суурийг бүрдүүллээ. Ингэснээр банк харилцагчтайгаа своп, форвард зэрэг санхүүгийн үүсмэл хэрэгслийн арилжааг хийж эхэлсэн нь гадаад валютын спот захын дарамтыг бууруулсан тул Монголбанк 2011 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс хойш спот захад оролцоогүй болно.

Монголбанк нь своп, форвард захыг хөгжүүлэх зорилгоор банкуудтай своп, форвард хэлцлийг бодлогын хувьд байгуулж байгаа бөгөөд тайлант хугацаанд 5 банкттай нийт 21 удаа 46.5 сая ам.долларын форвард хэлцэл, 2 удаа 4.0 сая ам.долларын төгрөгийн своп хэлцлийг байгуулсан байна. Үүний үр дүнд банкны харилцагч байгууллага, иргэдийн своп, форвард хэлцлээр байгуулсан 49.5 сая ам.долларын өртөг бүхий хөрөнгө ханшийн эрсдэлээс хамгаалагдсан. Хугацаа нь дууссан форвард хэлцлийн дагуу 20.0 сая ам.долларыг худалдан авсан бол, 6.0 сая ам.долларыг худалдсан бөгөөд энэхүү арилжааны тэнцлийн алдагдал 258.0 сая төгрөг байна. Гэхдээ дээрх своп, форвард хэлцлийг байгуулснаар Төв банкны үнэт цаасны хүүгийн зардлын хэмнэлт, ханшийн тэгшитгэлийн хэмнэлтийг бий болгож байгаа бөгөөд энэхүү хэмнэлт нь спот захад оролцоход гарах зардлаас илүү байна. Үүнээс дүгнэхэд нэг талаас ашигтай хэлцэл хийсэн банк, түүний цаана байгаа харилцагч хожиж байгаа бол нөгөө талаар, своп форвард хэлцлийн захыг хөгжүүлэхээр зорьж буй Монголбанкны бодлогын үр дүнд спот захад үзүүлэх дарамт тодорхой хэмжээгээр буурч, банкны харилцагчийн хувьд ирээдүйн ам.долларын урсгалыг зохицуулах боломж нэмэгдэж буй нь бодит эдийн засагт үзүүлж буй үр нөлөө билээ.

Монгол Улсын эдийн засагт хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдэж, гадаад зээлийн хэмжээ өсч байгаатай уялдан макро эдийн засаг, санхүүгийн системийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор Монголбанк тайлант хугацаанд: (i) хөрөнгийн дотогшлох урсгалтай үеийн бодлогын сонголтууд, олон улсын туршлагыг судлах, (ii) Монгол Улсын төлбөрийн тэнцлийг сар тутамд гаргадаг болох, (iii) Монгол Улсын гадаад зээлийн тойм мэдээллийг боловсруулах, төрийн холбогдох байгууллагад хүргүүлэх, (iv) хууль эрхзүйн орчинг боловсронгуй болгох хүрээнд “Валютын тухай” хуулийн төслийг эдийн засаг, зах зээлийн орчны өөрчлөлт, олон улсын чиг хандлагатай уялдуулан шинээр боловсруулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүллээ.

#### **Гадаад валютын улсын нөөц:**

Гадаад валютын улсын нөөц 2011 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2,343.28 сая ам.долларт хүрч, оны эхнээс 2.4%-иар буюу 55.5 сая ам.доллараар өссөн байна. Энэ нь 2010 оны валютын төлбөртэй импортын 9.7 сарын, 2011 оны хоёрдугаар сарын валютын төлбөртэй импортын 11.3 сарын, 2011 оны импортын төсөөллөөр 6.1 сарын хэрэгцээг тус тус хангах түвшин юм.

Тайлант хугацаанд ГВУН ийнхүү нэмэгдэхэд i) Монголбанк гадаад валютын дуудлага худалдаа, форвард хэлцлээр банкуудаас гадаад валют худалдан авсан, ii) нөөцийг бүрдүүлэгч голлох валютуудын ханш ам.долларын эсрэг чангарсан, iv) нөөцийн удирдлагын орлого 1.9 сая ам.долларт хүрсэн зэрэг голлох урсгалууд нөлөөлжээ.

**Зураг 5. Гадаад валютын улсын нөөцийн хангалттай байдал /импортын гүйцэтгэлээр/**



Монголбанк нь гадаад валютын улсын нөөцийн удирдлагыг түүний найдвартай байдал, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, өгөөжийг тус тус ханган хэрэгжүүллээ. Тайлант хугацаанд Монголбанк нь харилцах, хадгаламжийн хүүгийн орлогоос нийт 0.83 сая, богино, урт хугацааны үнэт цаасны хөрөнгө оруулалт, арилжааны орлогоос 1.07 сая ам.долларын ашиг олсноор ГВУН-ийг 1.9 сая ам.доллараар нэмэгдүүлсэн байна. Үүний үр дүнд, ГВУН эрсдэлд ороогүй, Монгол Улсын гадаад төлбөр тооцоо сааталгүй хэвийн явагдсан. Монголбанк алт олборлогч аж ахуйн нэгж, иргэдээс 2011 оны 1 дүгээр улиралд 310.1 кг алт худалдан авсан нь өмнөх оны мөн үеэс 2.2 дахин нэмэгдсэн байна.

**1.4 Монголбанк санхүүгийн зах зээл дээр урт хугацаатай эх үүсвэр бий болгох арга хэмжээ авна. Үнэт цаасны зах зээлийг өргөтгөн банкны салбарт үүссэн мөнгөн хуримтлалыг эдийн засгийн хөгжилд үр ашигтай ашиглах асуудлыг Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран судалж, холбогдох арга хэмжээ авна.**

Монголбанк Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн дагуу Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэж, Засгийн газрын үнэт цаасыг зуучлан борлуулах бэлтгэл ажил хийж Сангийн яаманд хүргүүлээд байна. Монголбанк нь засгийн газрын үнэт цаасыг арилжаалах бүтэц, зарчмыг агуулсан “Засгийн газрын үнэт цаасыг гаргах, арилжаалах журам”-ын төслийг боловсруулан холбогдох байгууллагуудад танилцууллаа. Үүний зэрэгцээ арилжааны дэд бүтцийг бий болгох програм хангамжийг боловсронгуй болгож байна.

Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-ны арилжааны зорилго нь төсвийн орлого, зарлагын хугацааны зөрүүнээс үүссэн төсвийн алдагдлыг богино (төсвийн урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр) болон урт (эдийн засгийн өсөлтийг дэмжих урт хугацааны санхүүгийн эх үүсвэр) хугацаанд үр ашигтай, хамгийн бага зардлаар санхүүжүүлэх, ЗГҮЦ-ны хоёрдогч захыг хөгжүүлэх, түүнчлэн санхүүгийн зах (мөнгөний зах, хөрөнгийн зах)-ын хөгжлийг дэмжихэд оршино. Тиймээс эхний ээлжинд Засгийн газрын богино хугацаатай үнэт цаасны захыг хөгжүүлэхэд ач холбогдол өгч, төсвийн хөрөнгийн удирдлагыг сайжруулж, институциональ хөрөнгө оруулагчдыг бий болгож хөгжүүлэх шаардлагатай байна. ЗГҮЦ гаргах, арилжаалах журмын төслийг боловсруулахдаа санхүүгийн зах зээл амжилттай хөгжсөн бусад орны туршлагаас судалж, өөрийн орны эдийн засаг, санхүүгийн захын хөгжилтэй уялдуулан, аль болох олон улсын жишигт ойртохуйц, арилжааны зохистой бүтцийн үндэс суурийг эхнээс нь зөв тавих зэрэг нөхцөлийг харгалзан үзсэн болно.


Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтолцоог бүрдүүлэн бэхжүүлэх талаар Сангийн яам, Хөгжлийн банк, МИК, банкуудтай хамтран ажиллаж байна. Бага, дунд орлоготой иргэдийг хямд, урт хугацааны орон сууцны санхүүжилтээр хангах бүтцийг бий болгоход тодорхой санал боловсруулан Сангийн яам, Хөгжлийн банк, ЗТБХБЯ-нд танилцуулж, Засгийн газраас хэрэгжүүлэх гэж буй “Шинэ бүтээн байгуулалт” төсөл хөтөлбөрийн хүрээнд Хөгжлийн банкныг хямд эх үүсвэрээр хангах тал дээр дэмжлэг үзүүлэх чиглэлтэй ажиллаж байна.

Жижиг, дунд үйлдвэрийн санхүүжилтэд зориулж Засгийн газраас жилийн 7 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай, 100 тэрбум төгрөгийн бонд гаргах ажлыг судлан боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮ-ийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2011 оны 1 дүгээр сарын 17-ны хамтарсан тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн ахлагчаар ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Т.Гантулга ажиллаж байгаа бөгөөд 2011 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр анхны хуралдаанаа зохион байгуулж ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөөг нарийвчлан баталсан. Дээрх асуудал нь Засгийн газрын яамдууд болох ХХААХҮЯ болон Сангийн яамны хооронд уг асдуулыг дахин судалж үзэж, хэлэлцэхээр болж хойшилсон.

### Хоёр. Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, цаашид өөрчлөн сайжруулах хүрээнд


#### 2.1 Банкны санхүүгийн чадавхийг бэхжүүлж, салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэн урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих” журмын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтүүдийг банкууд бүрэн хангаж ажиллаж байгаа эсэхэд хяналт тавьж, өөрийн хөрөнгийн хүрэлцээний талаарх судалгааг улирал бүр гарган хянаж байна. Мөн хяналт шалгалтын явцад “Банкны тухай хууль”-ийн 17 дугаар зүйлд заасан зарим хязгаарлалт болон дээрх журмын зээлийн төвлөрлийн эрсдлийн үзүүлэлтүүдийн биелэлтийг 2011 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хянахад зарим банкууд уг үзүүлэлтүүдийг зөрчсөн болох нь илэрсэн бөгөөд зөрчлийг бүрэн арилгах хугацаатай үүрэг даалгавар өгсөн болно.




“Банкны тухай хууль” болон “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих” журмын биелэлтэд сар бүр хяналт тавьж, банкуудаас ирүүлсэн санхүүгийн тайлан мэдээ, бусад холбогдох мэдээлэлд үндэслэн банкны үйл ажиллагаанд одоо болон ирээдүйд учирч болзошгүй аливаа эрсдлийн түвшинг тогтоож, хүндрэлтэй асуудлуудыг илрүүлэн, урьдчилан сэргийлэх арга

хэмжээг тухай бүр авч ажиллаж байгаагаас гадна мөн эрсдэл даах хүрэлцээтэй өөрийн хөрөнгө байгаа эсэхийг үнэлсэн.



**2. Банкны салбарын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангуулж, хяналт шалгалтыг цаашид сайжруулж, банкны зохистой засаглалын зарчмыг мөрдүүлэн санхүүгийн салбарын сахилга батыг өндөржүүлэх ажлын хүрээнд:**

“Банкны тухай хууль”-ийн 17 дугаар зүйлд заасан зарим хязгаарлалт болон "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналт тавих журам"-ын дагуу тодорхойлсон эрсдлийн түвшинг ижил түвшний болон системийн үзүүлэлтүүдтэй харьцуулсан мэдээг сар бүр банкуудад хүргүүлж байсан бөгөөд ингэж эрсдлийн түвшинг тогтоосны үндсэн дээр санхүү, төлбөрийн чадвар болон үйл ажиллагаанд үнэлэлт өгч ажилласан.



Банкны үйл ажиллагаанд тавьж байгаа хяналт шалгалтыг сайжруулах ажлын хүрээнд хянан шалгагч нарыг сургалтанд хамруулж, мөн банкны системийн тогтвортой байдлыг хангах үүднээс дээрх журамд “Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны тайлан”-г хавсралтаар оруулж, харьцааг 18 хувиар тооцож байх нэмэлт өөрчлөлтийг оруулахаар төлөвлөж байна.

Зээлийн мэдээллийн сангийн хамрах хүрээг өргөтгөх зорилгоор санхүүгийн бус салбарт үүсээд буй зээлдүүлэгч байгууллагуудад бүртгэлгүй иргэд, аж ахуй нэгжийн өр төлбөрийг зээлийн мэдээллийн санд оруулахын тулд Монголбанкны зүгээс мэдээлэл солилцож, хамтран ажиллах талаар холбогдох байгууллагуудад албан хүсэлт тавьж, зөвшилцсөнөөр зарим байгууллагуудтай хамтран ажиллаж эхлээд байна. Одоогоор суурин утас болон нийгмийн даатгалын өр төлбөрийн мэдээллийг зээлийн мэдээллийн



санд нэгтгэх ажлыг хийж эхлээд байгаа бол үүрэн утас, эрчим хүч, дулаан болон татварын өр төлбөрийн мэдээллийг зээлийн мэдээллийн санд нэгтгэх талаар холбогдох байгууллагуудтай тодорхой зөвшилцөлд хүрч, техникийн шинж чанартай ажлуудыг хийж эхлүүлэхээр төлөвлөөд байна. Үүнээс гадна банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодын мэдээллийг зээлийн мэдээллийн санд бүрэн хамруулах Micro finance 1.0 програмыг Санхүүгийн зохицуулах хороотой хамтран туршиж, ашиглалтад оруулан бүх бичил санхүүгийн байгууллагуудад тарааж, техникийн хувьд хүндрэлтэй байсан асуудлыг шийдвэрлэсэн. Энэ улиралд шинээр 9 банк бус санхүүгийн байгууллага, 3 хадгаламж зээлийн хоршоо хамтран ажиллаж эхэллээ. Шинээр нэмэгдсэн 12 бичил санхүүгийн байгууллагыг оруулаад зээлийн мэдээллийн сан 24 бичил санхүүгийн байгууллагатай мэдээлэл солилцон ажиллаж байна.

Банкуудын 2010 оны 2 дугаар хагас жилийн “Банкуудын зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын биелэлтийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 311 дүгээр тушаалаар батлагдсан “Банкуудын зохистой удирдлагын хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний загвар”-ын дагуу үнэлж дүгнэв. Үүнээс гадна Банкны тухай хууль, “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналт тавих журам”, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 тоот тушаалаар “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам” болон холбогдох бусад журмуудын хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Нэгдсэн хяналт шалгалтын эрх зүйн орчинг сайжруулах зорилгоор Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2011 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн удирдамжийн дагуу Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкуудаас аж ахуйн нэгж, иргэдэд олгож буй зээл, зээлийн хүү, шимтгэл болон тэдгээртэй байгуулж буй гэрээ нь Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжид нийцэж байгаа эсэхийг тогтоох зорилгоор 2011 оны 2 дугаар сарын 16-ны өдрөөс 3 дугаар сарын 11-ний өдөр хүртэлх хугацаанд шалгалт хийсэн. Мөн нэгдсэн хяналт шалгалтын журмын төслийг орчуулан 2011 оны 3 дугаар сард Азийн хөгжлийн банкны зөвлөхүүдэд хүргүүлсэн бөгөөд зөвлөхүүдээс саналаа эхний байдлаар гарган ирүүлээд байна.

**2.3 Хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх, барьцаа хөрөнгийн хөрвөх чадварыг сайжруулах, өнөөгийн банкны нийтлэг үйлчилгээнээс гадна хөгжлийн болон хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийг өргөжүүлэн, хөрөнгийн захын хөгжлийг дэмжинэ.**

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2010 оны 11-р сарын 3-ны өдрийн 640/239 тоот хамтарсан тушаалаар “Иргэдийн мөнгөн хадгаламжийн даатгалын тухай” хуулийн төслийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны төлөөлөлтэйгээр байгуулсан. Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Солонгосын хөгжлийн институтээс хадгаламжийн даатгалын хуулийн төслийг боловсруулахад зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна. Үүнтэй холбоотойгоор Дэлхийн банк болон Солонгосын хөгжлийн институтээс хадгаламжийн даатгалын сэдвээр зохион байгуулсан семинаруудад оролцож, санал бодол солилцсон.

Ажлын хэсгийн 2011 оны 1-р сарын 14-ний хуралдаанаар ажлын хэсгийн гишүүдийг судалгаа хийх болон хуулийн төсөл боловсруулах гэсэн хоёр дэд ажлын хэсэгт хуваасан. Судалгааны дэд ажлын хэсгээс хадгаламжийн даатгалтай холбоотой судалгааг хийж, гол асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар санал гарган ажлын хэсэгт танилцуулж шийдвэрлүүлсэн бөгөөд үүнд үндэслэн хуулийн үзэл баримтлал болон

танилцуулгыг бэлтгэсэн. Ажлын хэсгийн зарим гишүүд Азийн хөгжлийн банкны зөвлөхийн туслалцаатай хуулийн төслийг шинэчлэн боловсруулсан бөгөөд одоо шинэчилсэн хуулийн төслийг сайжруулах, холбогдох талуудад танилцуулж, санал авах ажил хийгдэж байна. Шинэчилсэн хуулийн төслийг ажлын хэсгийн тушаалын дагуу Монголбанкны Захирлуудын зөвлөлд танилцуулсан бөгөөд Яамдуудаас санал авч, 5-р сард Улсын их хуралд өргөн барихаар ажиллаж байна.

Үүнээс гадна барьцаа хөрөнгийн холбогдолтой болон зээлийг түргэн шуурхай барагдуулах чиглэлээр эрх зүйн орчинг сайжруулах, хуульд оруулах нэмэлт өөрчлөлтүүдийн төслийг боловсруулах ажлын хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 53 тоот тушаалаар байгуулан ажиллаж байна. Энэ хугацаанд ажлын хэсэг Азийн хөгжлийн банкны зөвлөхүүд болон банкуудын хуульч, өр барагдуулах албаныхантай 2 удаа хуралдаж, Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж хамтран ажиллахаар тохиролцсон. Түүнчлэн банкуудын хуульчид болон ажлын хэсгийнхэнд олон улсын туршлага, стандартын талаарх сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан юм.

Сангийн сайдын 2010 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 261 тушаалаар байгуулагдсан “Хөгжлийн банкны тухай” хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт Монголбанкны эрх бүхий ажилтнууд орж ажилласан. Ажлын хэсгээс боловсруулсан хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцэн 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн тогтоолоор “Монгол Улсын Хөгжлийн Банкны тухай” хуулийг баталсан. Монголбанкнаас оруулсан саналын дагуу уг хуулийн 27.5-д Хөгжлийн банк нь холбогдох тайлан, мэдээллийг Монголбанкны баталсан загвар, маягтын дагуу гаргаж, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд тогтмол тус тус хүргүүлнэ гэсэн заалтыг оруулсан юм. Мөн уг хууль батлагдсантай холбогдуулан Төв банкны тухай болон Банкны тухай хуулиуд нь Хөгжлийн банкинд хамаарахгүй тухай нэмэлт өөрчлөлтүүдийг эдгээр хуулиудад оруулж өгсөн.

Хөрөнгийн зах зээл дэх банкуудын оролцоог дэмжих тал дээр Худалдаа хөгжлийн банкнаас банкуудын эдийн засгийн өсөлт болон харилцагчдын санхүүгийн эрэлт хэрэгцээг хангах, тэдгээрт зориулсан бага хүүтэй, урт хугацаат бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор гаргасан 150.0 сая ам долларын 3 жилийн хугацаатай бондыг олон улсын хөрөнгийн зах зээл дээр амжилттай арилжаалахад нь зөвшөөрөл олгож, дэмжлэг үзүүлэн хяналт тавьж ажилласан. Цаашид бусад банкуудын хөрөнгийн зах зээл дэх оролцоог дэмжиж ажиллах болно. Мөн Голомт банк болон Худалдаа хөгжлийн банкны охин компани болох “Ти Ди Би Капитал” ХХК-ийн хувьд “андеррайтерын үйлчилгээ” болон “харилцагчийн нэрийн өмнөөс гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад үйлчилгээ” үзүүлэх зөвшөөрлийг дэмжиж СЗХ-нд тодорхойлолт гаргаж өгсөн.

### **Гурав. Төв банкны бусад үйл ажиллагааны хүрээнд**

#### **3.1 Монгол улсын төлбөр тооцооны системийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажиллана.**

Төлбөрийн системийн хуулийн төслийг боловсруулж УИХ-д өргөн барих ажил нь IY улиралд хийхээр төлөвлөсөн. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 101 дүгээр тушаалаар Төлбөрийн системийн тухай хууль боловсруулах Ажлын хэсэг байгуулсан. Монголбанкны ТБЗА нь Төлбөрийн системийн тухай хуулийг боловсруулж дууссан, 2011 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн Ажлын хэсгийн анх дугаар хуралдаанаар уг хуулийн төсөл болон Ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөөг тус тус танилцуулсан.

“Банксүлжээ” систем, банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны систем болон төлбөрийн картын сүлжээний найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт 26,1 тэрбум төгрөгийн дүнтэй 527 мянган ширхэг картын гүйлгээ, 78,9 тэрбум төгрөгийн дүнтэй 619 мянган ширхэг бага дүнтэй гүйлгээг ТТТ хийлээ. Банксүлжээ системээр 27,3 их наяд төгрөгийн дүнтэй 130 мянган ширхэг их дүнтэй гүйлгээ хийжээ. Систем найдвартай ажиллаж байна.

**3.2 Монголбанк мөнгөний бодлого, арга хэрэгслийг олон нийтэд ил тод, нээлттэй байлган өөрийн хариуцлагыг дээшлүүлнэ. Мөнгөний бодлогын зорилт, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хүлээгдэж байгаа үр дүнг тогтмол тайлбарлан таниулж иргэд, олон нийтийн зүгээс түүнд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.**

Монголбанк мөнгөний бодлого, бусад үйл ажилагаатай холбоотой мэдээллийг олон нийтэд хүргэхэд цахим хуудсын мэдээлэлд тулгуурлан ажилладаг. Төв банкны цахим хуудасыг шинэчлэн 2011 оны 4 дүгээр сарын 11-нд ашиглалтанд оруулж, Санхүүгийн тогтвортой байдал, Төлбөрийн систем, Санхүүгийн мэдээллийн алба, Банкны сургалтын төв зэрэг үндсэн болон туслах цэсүүд нэмлээ.

Олон нийтэд мэдээлэл түгээх идэвхитэй хэлбэр болгон урьдчилан зарласан хэвлэлийн бага хурлыг 2011 оны турш зохион байгуулах юм. Хэвлэлийн хурлын товыг цахим хуудсан дээр байршуулан олон нийтэд зарласан. Уг хуваарийн дагуу 2011 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр Монголбанк 2010 оны ажлаа тайлагнаж, 2 дугаар сарын 24-нд мөнгөний бодлогын шийдвэр гаргалт, өөрчлөлт, түүний шалтгаан болон хэрэгжилт, 3 дугаар сарын 24-ний өдөр төлбөрийн тэнцэл, инфляци зэрэг асуудлаар зохион байгуулав. Холбогдох мэдээ, материал болон хэвлэлийн мэдэгдлийг цахим хуудсан дээр байршуулж байна.

2011 оны I улирлын Инфляцийн хүлээлтийн судалгааг өмнөх судалгаануудын хамтаар цахим хуудасны “Мөнгөний Бодлого” үндсэн цэс дотор байршууллаа. Үндсэн зорилт болон хараат бус байдлын талаар ярилцлага мэдээллийг сонин хэвлэлд нийтлүүлсэн. Мөн тус асуудлаар ярилцлага өгөх, сургалт семинараар дамжуулан тайлбарлан танилцуулах ажлыг зохион байгуулсан.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_